



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 1/378

Есөнбулаг сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 50.000.000 (тавин сая) төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх "өндөр ашиг шимтэй малын загвар аж ахуй байгуулах" ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан, хэрэгжүүлэх эрхийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Очир)-т шилжүүлсүгэй.

2. Ажил гүйцэтгэх хугацаа, ажлын төлөвлөгөөг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүргийг хэрэгжүүлж, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Очир)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

